

“СОВРЕМЕННЫЕ РОССИЙСКО-МОНГОЛЬСКИЕ ОТНОШЕНИЯ: МОДЕЛИ И СЦЕНАРИЙ” ХАМТЫН БҮТЭЭЛ ХЭВЛЭГДЭН ГАРЛАА

2012-2013 онд БШУЯ-ны Шинжлэх ухаан технологийн сан, ОХУ-ын Хүмүүнлэгийн сангийн санхүүжилтээр ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэн, ОХУ-ын Буриадын Улсын Их Сургуультай хамтран хэрэгжүүлсэн “Возвращение России в Монголию: модели и сценарии” (“Орос Монголд эргэн ирсэн нь: загвар ба төсөөллүүд”) төслийн хүрээнд хэвлэгдэн гарсан “Современные российско-монгольские отношения: модели и сценарии” (“Орчин үеийн Орос-Монголын харилцаа: загвар ба төсөөллүүд”) ном 2013 оны сүүлээр хэвлэгдэн гарлаа.

Уг ном нь манай хүрээлэнгийн 3 дахь хамтарсан ном бөгөөд анхны ном нь ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнтэй “Россия и Монголия: новый взгляд на историю взаимоотношений в XX веке” (Орос-Монгол: XX зууны харилцааны түүхийн шинэ үзэл бодол”) хамтын бүтээл Москва хотноо 2001 онд, мөн тус хүрээлэнтэй хамтран “Россия и Монголия на пути стратегического партнерства” (Орос, Монгол стратегийн түншлэлийн замд) хамтын бүтээл 2011 онд Москва хотноо тус тус хэвлэгдэн гарсан.

Уг хамтын бүтээлд Монголын талаас ШУА-ийн ОУСХ-ийн доктор Д.Шүрхүү, доктор А.Нямдолжин, доктор К.Дэмбэрэл, доктор А.Даваасүрэн, магистр Ж.Орхон, Оросын талаас Буриадын Улсын Их сургуулийн доктор В.А.Родионов, доктор И.Г.Актамов, доктор Д.Д. Бадараев, доктор Т.Б. Бадмацыренов, доктор И.Ц. Доржиева нар оролцов.

Уг ном нь 3 бүлэгтэй, тухайлбал: “Орос-Монголын харилцаа: арга зүйн хайлт” нэгдүгээр бүлэгт орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд олон улсын харилцааны тогтолцооны загваруудыг дэлгэрэнгүй авч үзэн, Орос-Монголын харилцааны загваруудыг арга зүйн талаас нь тодорхойлж өгсөн, тухайлбал реализм, марксист, либерализм гэх мэт, ингэхдээ эдгээрийг онолын талаас дэлгэрэнгүй тайлбарлаж, Орос болон Монголын судлаач, эрдэмтдийн онол арга зүйн түүхэн замнал болон тэдгээрийн бүтээлүүдийн талаар өгүүлсэн.

Хоёрдугаар бүлэг буюу "Орос ба Монгол: ХХ зуун дахь харилцааны өөрчлөлт" бүлэгт Орос-Монголын харилцааны түүхийг XVII-XX зуун хүртэл, постсоциалист болон стратегийн түншлэлийн хэмжээнд хүртэл дэлгэрэнгүй авч үзэн, зарим түүхийн ээдрээтэй асуудлуудыг шинэлэг аргаар тусгаж харуулахыг зорьсон. Түүнчлэн эл бүлэгт хоёр орны худалдаа-эдийн засгийн харилцаанд тулгамдаж буй асуудлууд, соёл, болосврол, хүмүүнлэг, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа болон манай хоёр улсын харилцааны гол субъект болох хил орчим, бүс нутгийн харилцаа хамтын ажилгааны өнөөгийн байдлыг тусган харуулсан байна.

"Орос-Монголын харилцааны загварууд: ирээдүйн төсөөллүүд" гуравдугаар бүлэгт Орос-Монголын харилцааны загвар, төсөөллүүдийг онолын үүднээс харуулахыг зорьж үүний тулд зохиогчид хоёр орны харилцааны загваруудыг тодорхойлохдоо боломжит загваруудыг шинэлэг, урьд өмнө байгаагүй хэлбэрээр харуулсан, жишээ нь Их Монгол буюу шинэ Панмонголизм, Оросын эсрэг блок буюу гуравдагч орнуудтай байгуулах холбоо, түүнчлэн холбоотны загвар гэсэн загварт "том ах" буюу Орос-Монголын шинэ холбоо, бүс нутгийн гурвалжин гэх мэт, мөн хамтын ажиллаганы загваруудыг status quo буюу тэнцвэртэй хөндийрөл-аюулгүй байдлын баталгаа гэсэн загваруудыг маш дэлгэрэнгүй харуулахыг зорив.

Уг бүтээлийн гол зорилго нь Монгол Улсын талаар явуулж буй ОХУ-ын бодлогод дүн шинжилгээ хийх, түүний дотор Монголтой харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйлсийг тодорхойлоход оршиж ОХУ-ын Монголд эргэн ирэх хэв загварууд, байж болзошгүй сценари/төсөөллүүдийн талаар таамаглал дэвшүүлж, зохих тайлбарыг хийхийг эрмэлзсэн шинэлэг бүтээл болж чадсан.

Монгол-Оросын хоёр талын харилцааны ирээдүйн төлөв байдлын талаарх судалгааг хоёр орны эрдэмтдийн хамтын хүчээр анх удаа явуулсанд оршино. Оролцогчдын хувьд гол төлөв залуу эрдэмтэд гүйцэтгэсэн бөгөөд судалгааны үр дүнг хоёр орны бодлого боловсруулах, шийдвэр гаргах төр засгийн байгууллагуудын эрэлт хэрэгцээнд ашиглаад зогсохгүй Монголд үйл ажиллагаа явуулж буй ОХУ-ын хувийн

болон улсын бизнесийн бүтцүүд ч ашиглах боломжтой юм. Монголын талд ч ОХУ-ын бодлогын мөн чанар, чиглэл, зорилгыг таньж мэдэхэд чухал ач холбогдолтой.

Иймээс сүүлийн үед Орос-Монголын харилцааны талаар дорвитой бүтээл гараагүй байсныг засч залруулан, уг бүтээл хуучин улиг болсон хэв маягаас тэс өөр, шинэлэг бүтээл болсон гэдэгт эргэлзэхгүй байна.

Мөн уг номонд орчин үеийн Орос-Монголын харилцааны талаар мэргэжлийн судлаач нарын дунд социологийн судалгаа явуулж үр дүнг нийтэлсэн болно.

Бичсэн Ж.Орхон